ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

# МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР ТУТМЫН ТОЙМ

**2017.01**

## Үзүүлэлтүүд:

| ДНБ 1% | ГШХО 12-р сард | Төсвийн алдагдал | Инфляци | Чанаргүй зээл | Валютын нөөц |
|---|---|---|---|---|---|
| 2016 оны IV-р улирлын байдлаар | **-120.6 сая ам.доллар** | **-25.3 тэрбум төгрөг** | 3.3% | **1052 тэрбум төгрөг** | **1 тэрбум ам.доллар** |
| Хөдөө аж ахуйн салбар 13 хувь, үйлчилгээний салбар 10 хувиар өссөн нь нөлөөлөв. | Цэвэр ГШХО 12-р сарын байдлаар -120.6 сая ам.доллар өмнөх оны мөн үеэс 51.3 сая ам.долларааар буурав. | Төсвийн орлого 483.4 тэрбум төгрөг, зарлага 465.8 тэрбум төгрөг болж тэнцэл (25.3) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. | Өмнөх сараас 1.1 хувиар, оны эхнээс 1.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 3.3 хувь өссөн байна. | Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.8 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувиар нэмэгдэж 1038 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.3% | Монголбанкны валютын нөөц 12-р сард өмнөх оны мөн үеэс 2 хувь буюу 27 сая ам.долларааар буурч 1296 сая ам.доллар болов. |

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

**2488.38 ₮**

Орон сууцны үнийн индекс

**0.981**

Өмнөх сараас 2.8%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 7.1%-иар буурав.

**Монголбанкны** бодлогын хүү

**14%**

2017 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр буюу Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн өдрийг тохиолдуулан жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслол болов.

## Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүллээ.







Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

| Голлох бүтээгдэхүүн | 2015 он | | 2016 он | | 2017 оны 1-р сар | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэмжээ | Орлого | Хэмжээ | Орлого | Хэмжээ | Орлого |
| Чулуун нүүрс | 14.4 | 0.6 | 25.7 | 9.7 | 2.5 | 1.6 |
| Төмрийн хүдэр | 6.3 | 0.2 | 6.1 | 2.4 | 2.5 | 1.5 |
| Зэсийн баяжмал | 1.4 | 2.3 | 1.5 | 1.6 | 1.3 | 1.3 |
| Нийт | 22 | 3 | 33 | 14 | 6 | 4 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

*2017 оны эхний өдрөөс оны эхний өдрөөс эхлэн гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифыг тэглэхээр болсон бөгөөд 25.8 тэрбумын алдагдлыг хүлээж уг шийдвэрийг хэрэгжүүлэхээр болсон байна.*

### *ДНБ*

ДНБ 2016 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 16 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 65.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 1 хувиар өсөв. ДНБ-ий 1 хувиар өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 13 хувь, үйлчилгээний салбар 10 хувиар өссөн нь нөлөөлөв.

### *Төсөв*

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 44.2 хувиар,зарлага 12.3 хувь өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 25.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 54.4 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 19.1 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.




### *Валютын ханш*

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 485.1 төгрөг буюу 24.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 5.8 төгрөг буюу 0.2 хувиар өсч 2488.38 төгрөгөөр сулрав.

### *Инфляци*

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 1-р сард өмнөх сараас 1.1 хувь, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсч , өмнөх оны эцсээс 3.3 хувиар өсөв. Өмнөх оны мөн үеэс өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 6.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 4.3 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 3.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

** Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж ҮСХ, Монголбанк*

### *Гадаад валютын нөөц*

Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 12-р сарын байдлаар1296 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 0.5 хувь буюу 8 сая ам.долларааp,өнгөрсөн оны мөн үеэс 2 хувь буюу 27 сая ам.долларааp тус тус буурсан үзүүлэлттэй байна.




** Эх сурвалж Монголбанк*

### *MSE-20 индекс*

2017 оны нэгдүгээр сард 37.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 26 сая үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 5.6 хувиар буурсан бол арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 25 хувь, өмнөх сараас 32.2 хувь буурсан байна. ТОП-20 дундаж индекс 2017 оны нэгдүгээр сард 12237 нэгж болж, өмнөх сарынхаас 632, өмнөх оны мөн үеийнхээс 79.7 нэгжээр буурчээ.




**Монголын хөрөнгийн биржс*

***Мөнгө***

Мөнгөний нийлүүлэлт (М2) мөнгө өмнөх оны мөн үеэс 20 хувиар нэмэгдэж, өнгөрсөн сараас 1.6 хувиар буурч 11 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 6.9 хувиар өсч, өмнөх сараас 7.4 хувиар буурч улмаар нийт мөнгөний 6.4 хувийг эзэлж байна.

***Хадгаламж***

Нийт хадгаламж 2017 оны 1-р сард 8.4 их наяд төгрөг болж өмнөх сараас 108 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар буурав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 15.7 хувиар буюу 1143.1 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 8.5 хувиар буюу 235.8 тэрбум төгрөгөөр буурсан бол төгрөгийн хадгаламж 11 хувиар буюу 127.8 төгрөгөөр өсөв.




***Зээл***

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 1-р сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 5.1 хувиар нэмэгдэж 12.3 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1038 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.8 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.3% байна.

***Ипотекийн зээл***

2017 оны 1-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.4 хувь (16.6 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.5 хувь (600 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4 их наяд төгрөгт хүрэв. Нэгдүгээр сард нийт 326 зээлдэгчид 38.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 89482-д хүрэв. 2017 оны нэгдүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.3 хувь нь төгрөгийн зээл, 0.7 хувь нь валютын зээл байна.



## Гадаад худалдаа

***Гадаад худалдаа***

2017 оны нэгдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 705.7 сая ам.доллар,үүнээс экспорт 428.5 сая ам.доллар, импорт 277 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 151.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2.2 хувиар буурч, экспортын хэмжээ 5.3 хувиар өссөн бол импортын хэмжээ 11.5 хувиар буурсан байна. Экспорт 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 99.4 (30.2 хувь) сая ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 115.2 сая ам.доллар, үүнээс нүүрсний экспорт 134.9 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.




* *Эх сурвалж УСХ, Монголбанк*

***Гадаадын шууд хөрөнгө оруулалт***

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оны 12-р сард -120.6 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 51.3 сая ам.долларааp буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -1.9 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 122.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.

* *Эх сурвалж Монголбанк*

## Монгол Улсын гадаад өр

*Гадаад өр*

2016 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4.7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 23.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 1 хувь (53 сая ам.доллар) , Улсын нийт гадаад өр 1 хувь (335 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* *Эх сурвалж Монголбанк*

## *Сарын онцлох үйл явдал*

***1.20***

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ энэ сарын 01-нээс 25 хувиар нэмэгдэж, 240 мянган төгрөг байхаар тогтоов. 2013 онд 192000 төгрөг болгосноос хойш өөрчлөлт ороогүй байсан бөгөөд өнгөрсөн онд МҮЭХ-ноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 хувиар нэмэгдүүлэхийг шаардсан ч Засгийн газар болон Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос эдийн засаг хүндрэлтэй байгаа тул биелүүлэх боломжгүй гэж үзсэнээр 25 хувь дээр тогтсон байна.

***1.17-20***

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Швейцарын Холбооны Улсын Давос хотноо энэ сарын 17-20-ны өдөр Дэлхийн эдийн засгийн 47 дугаар чуулга уулзалтад оролцов. Энэ удаагийн чуулга уулзалтад 80 орчим улсын төр, засгийн өндөр, дээд хэмжээний төлөөлөгч, олон улсын 40 орчим байгууллагын удирдлага болон улс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн 2600 гаруй төлөөлөгч цугларав.

***1.20***

2016 оны эцсийн байдлаар Монгол Улс эрдсийн экспортын хувьд өнгөрсөн онд 46 хувийг зэсийн баяжмал, 28 хувийг чулуун нүүрс, 21.7 хувийг алт бүрдүүлэв. Энэ дунд алтны экспорт 2015 оноос 1.8 дахин нэмэгдэж, 758.4 сая ам.долларт хүрсэн байна. 17.7 мянган кг алт экспортлосны дийлэнхийг Их Британи, Швейцарь улсад нийлүүлжээ. Түүнчлэн 2016 онд Монгол Улс нийт 1.5 сая тонн зэсийн баяжмалыг 1.6 сая ам.долларааар 100 хувь урд хөршид экспортложээ. Энэ нь 2015 онтой харьцуулбал биет хэмжээний хувьд 5.6 хувиар өссөн ч мөнгөн дүн нь 1.4 дахин буурсан байна. Харин “Оюу Толгой” компанийн хувьд 2016 онд 819.8 мянган тонн зэсийн баяжмал худалдсан бөгөөд энэ нь Монгол Улсын нийт экспортын 55 орчмыг бүрдүүлж байна.